Төрийн албаны зөвлөлийн
2019 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн
352 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☑ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар | Нийгмийн эрүүл мэндийн төв |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл |
|---|---|
| Нийгмийн эрүүл мэндийн төвийн дарга | Ахлах түшмэл, ТЗ-7 |

| Ажлын цаг | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдөр 8 цаг | Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, Эрүүл мэндийн газар |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбарын нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлогыг зохион байгуулах, эрүүл мэндийн байгууллагуудыг бодлогын зөвлөгөө, мэдээллээр хангаж, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх, хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг Эрүүл мэндийн газрын даргын өмнө хариуцна.

/22/2022

<u>Албан тушаалын зорилт:</u>

1.Эрүүл мэндийн хууль тогтоомж, төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, хяналт тавих, тайлагнах.

2.Хувь хүн, гэр бүл, аж ахуй нэгж байгууллага бусад салбар дундын оролцоотой хүн амын эрүүл мэндийг хамгаалж дэмжих, өвчлөлөөс урьдчилан сэргийлж, тандах, эрт илрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.

3.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг, дүрэм, журам, стандартыг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх- Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Үйл ажиллагаандаа хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар гарсан Монгол улсын хууль, тогтоомж, дүрэм, заавар, стандарт, удирдамжийг мөрдлөг болгон ажиллах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Т, Г, Х |
| | 2. Эрүүл мэндийн талаар гарсан хууль тогтоомж, хөтөлбөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагаас гаргасан эрхийн акт, норм, норматив, стандарт, удирдамж, мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн акт, шаардлагыг нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Т, Г, Х |
| | 3.Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудыг нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн удирдлага, үйл ажиллагааны нэгдсэн бодлого чиглэлээр хангаж ажиллах; | Холбогдох байгууллагуудыг хуульд нийцсэн бодлого удирдамжаар хангасан байна. | Т, Г, Х |
| | 4.Орон нутгийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй олон улсын төсөл, хөтөлбөрийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж, хэрэгжилтийн байдлыг хянах, тайлагнах; | Гадаад хамтын ажиллагааны дүнд дэвшилтэд арга барил нэвтэрсэн байна. | Т, Г, Х |

| | | | |
|---|---|---|---|
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Харъяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээг тодорхойлж, түүнд нийцүүлэн нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг оновчтой зохион байгуулах, үр дүнг тайлагнах; | Эрүүл мэндийн үйлчилгээний шуурхай байдлыг хангасан байна. | Т, Г, Х |
| | 2.Хүн амын дунд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ хийж, зонхилон тохиолдож буй өвчин эмгэгийг илрүүлэн эмчлэх шат дараатай арга хэмжээг удирдан зохион байгуулах; | Хүн амыг өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, эмчлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн хийсэн байна. | Т, Г, Х |
| | 3.Хүн амд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих үзүүлэх, эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх, халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж байгууллага, иргэд, орон нутгийн удирдлагыг мэргэжил, арга зүйгээр хангах; | Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчлөлөөс сэргийлэх талаар иргэн, хуулийн этгээдийг арга зүйгээр хангаж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, өвчлөлүүд буурсан байна. | Т, Г, Х |
| | 4. Нутаг дэвсгэрийн хэмжээнд халдварт болон халдварт бус өвчний тандалт судалгааг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион явуулах, өвчин үүсгэж буй халгаат хүчин зүйлийн эсрэг авах арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулж хэрэгжүүлэх; | | Т, Г, Х |
| | 5. Нутаг дэвсгэрийн хэмжээнд хүн амын дунд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэхэд чиглэсэн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгааг аж ахуйн нэгж байгууллага, төр болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах; | | Т, Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Эрүүл мэндийн газрын даргаас Зооноз өвчин судлалын төвийн даргатай байгуулсан гэрээ, өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй байгуулсан гурвалсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах; | Гэрээ хуульд нийцсэн байна. | Г, Х |
| | 2.Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаа болон бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэлт гарган холбогдох байгууллагуудад хугацаанд нь мэдээлж, үйл ажиллагаатай нь холбоотой эргэх мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах; | Хяналт шинжилгээ үнэлгээг хууль тогтоомжийн дагуу хийж мэдээ мэдээллээр хангасан байна. | Г, Х |

22/2022

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Хариуцсан хэлтсийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг эрх бүхий албан тушаалтнаар батлуулж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, тайлагнах; | Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтууд хангагдсан байна. | Х |
| | 4.Хариуцсан хэлтсийн албан хаагчдыг өдөр тутмын удирдлага, зөвлөмж, арга зүйгээр хангах, албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хяналт тавих, төрийн үйлчилгээг соёлтой шуурхай хүргэх нөхцлийг бүрүүлэх; | Хэлтсийн мэргэжилтнүүдийн чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна. | Г, Х |
| | 5.Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв тайлагнах; | Хууль хэрэгжүүлсэн байна. | Г |
| | 6.Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм, журмыг хэрэгжүүлэх; | Сахилга хариуцлага дээшилсэн байна. | Г, Х |
| | 7.Албан хэрэг хөтлөлт, архивын үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх стандартыг хэрэгжүүлэх; | Стандартыг мөрдүүлсэн байна. | Г, Х |
| | 8.Иргэдийн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулах; | Өргөдөл, гомдлыг хуулийн хүрээнд шийдвэрлэсэн байна. | Г, Х |
| | 9.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжид заасан чиг үүрэг бүрэн хэрэгжсэн байна. | Г, Х |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй. | |
| Мэргэжил | Анагаах ухаан /0912/, Нийгмийн эрүүл мэнд /091801/ | |
| Мэргэшил | Төрийн албаны мэргэшүүлэх богино, дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх | |
| Туршлага | Дэс түшмэлийн албан тушаалд 2-оос доошгүй жил, төрийн албанд 4-ээс доошгүй жил, ажилласан байх | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | -хариуцсан нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулах, гүйцэтгэлийг дүгнэх, тайлагнах, шаардлага тавьж чаддаг байх;<br>-удирдлагадаа байгаа албан хаагчдын ажил үүргийг |

| | | |
|---|---|---|
| | | оновчтой хуваарилах, удирдах;<br>-үйл ажиллагаа дахь эрсдлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;<br>-хэлтсийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлд өдөр тутам хяналт тавьж, хуульд нийцсэн зохих заавар чиглэл өгөх; |
| | Дүн шинжилгээ хийх | -албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх;<br>-шийдвэрийн шууд болон шууд бус үр дагаварыг үнэлж, шийдлийн хувилбарын талаар зөвлөх; |
| | Асуудал шийдвэрлэх | -хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>-шинэчлэл өөрчлөлт хийхийг зорьдог байх;<br>-өөрийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж чаддаг байх;<br>-аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>-ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>-хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>-бүтээлч, санаачилгатай ажиллах; |
| | Манлайлах | -ёс зүйгээр хамт олноо манлайлан үлгэр дууриал үзүүлэх<br>-ажил хэргийн хувьд бүтээлч, санаачлагатай ажиллах<br>-байгууллагын үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг хамт олондоо итгүүлэн ойлгуулах, хэрэгжүүлэх; |
| | Бусад | - Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын дотоод журамд заасны дагуу ажлын цагийг үр бүтээлтэй ашиглах;<br>- хувийн зохион байгуулалт сайтай, ёс зүйтэй ажиллах;<br>- компьютерийн хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах;<br>- төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, бичгийн чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; |

| IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ |
|---|
| <u>Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:</u><br>Эрүүл мэндийн газрын дарга |

<table>
<tr><td>Албан тушаалд шууд харьяалан Удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br><br>Ахлах мэргэжилтэн<br>Мэргэжилтэн</td><td>Бусад харилцах субъект :<br>-Эрүүл мэндийн яамны холбогдох нэгжийн дарга, албан хаагч;<br>-эрүүл мэндийн хөгжлийн төвийн холбогдох албан хаагч<br>-аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны холбогдох ажилтан;<br>-аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын холбогдох албан тушаалтан;<br>-эрүүл мэндийн бусад байгууллагууд;<br>-төрийн болон төрийн бус байгууллагууд;<br>- иргэн, хуулийн этгээд;</td></tr>
<tr><td colspan="2">V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ</td></tr>
<tr><td>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</td><td>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</td></tr>
<tr><td>Албан тушаал:<br>АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ ..........................Б.БАТЧИМЭГ<br>(Гарын үсэг)<br>2019 оны 12 дугаар сарын 13 –ны өдөр</td><td>Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 19 12 04<br>Дугаар: 352</td></tr>
<tr><td colspan="2">Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</td></tr>
<tr><td colspan="2">Байгууллагын нэр.<br>ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР<br>Шийдвэрийн огноо 2019-12-20<br>Дугаар А/116<br>)тамга/тэмдэг(<br>ДАРГА .......................... М.ҮҮРИЙНБАЯР<br>2019 оны 12 дугаар сарын 20 -ны өдөр</td></tr>
</table>